



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2018 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 175

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1. Тавантолгой-Зүүнбаян, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замыг барьж байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, холбогдох тооцоо, судалгааг боловсруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын хэсгийн
ахлагч

-Зам, тээврийн хөгжлийн сайд Я.Содбаатар.

Гишүүд:

-Сангийн дэд сайд Х.Булгантуяа;

-Зам, тээврийн хөгжлийн дэд сайд
Л.Халтар;

-Ерөнхий сайдын орон тооны бус зөвлөх
Ж.Бат-Эрдэнэ;

-Газар зохион байгуулалт, геодези, зураг
зүйн газрын дарга Ц.Ганхүү;

-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын дарга Ц.Ням-Осор;

-Дорноговь аймгийн Засаг дарга
Т.Энхтүвшин;

-Өмнөговь аймгийн Засаг дарга
Н.Наранбаатар;

-Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын
газрын захирал Т.Жанабазар;

-Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого,
төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч Ж.Сэрээтэр;

-Барилга, хот байгуулалтын яамны Хот
байгуулалт, газрын харилцааны бодлогын
хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Б.Гүнболд;

-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны
Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн
удирдлагын газрын дарга Г.Нямдаваа;

-“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг;

-Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Цэнгэл;

-“Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн замын дарга Д.Жигжиднямаа;

-“Улаанбаатар төмөр зам” Техникийн бодлого, зураг төсөл, инженерийн албаны дарга Ш.Эрдэнэбулган;

-“Дорнын төмөр зам” ХХК-ийн захирал С.Сүхбаатар.

Нарийн бичгийн
дарга

-Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Батболд.

2. Техник, эдийн засгийн үндэслэл, холбогдох тооцоо, судалгааг 2018 онд багтаан боловсруулж, Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ